



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 84

Арвайхээр

Г

**Бодлого батлах тухай**

Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн мал аж ахуйн салбарт 2021-2026 онд хэрэгжүүлэх "Таван төрлийн малын үржлийн талаар баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.
2. Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.
3. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт суулган, хэрэгжилт, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д үүрэг болгосугай.



О.ПҮРЭВДОРЖ



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ҮРЖЛИЙН АЖЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1 Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал:

Аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд мал аж ахуйн салбар нь голлох үүргийг гүйцэтгэж, хүн ардаа хүнсээр, үйлдвэрийг түүхий эдээр хангаж байна. Аймгийн хэмжээнд нийт хүн амын 68.3 хувь буюу 79751 нь хөдөлмөрийн насны хүн ам байгаас 24380 буюу 30.5 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна. Манай аймаг жилд дунджаар 657.8 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас мал аж ахуйн салбар 299,7 тэрбум төгрөгийн буюу 45.6 хувийг үйлдвэрлэж байна.

2020 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 4479.1 мянган толгойд хүрч, өмнөх оноос 1146.4 мянган толгойгоор буурсан ба төрлөөр авч үзвэл тэмээ 26.6 мянга, адуу 280.1 мянга, үхэр 251.8 мянга, хонь 2115.0 мянга, ямаа 1805.6 мянга болж, тэмээ 18.8 хувь буюу 6.1 мянган толгойгоор, адуу 19.7 хувь буюу 68.8 мянган толгой, үхэр 13.9 хувь буюу 40.6 мянган толгой, хонь 18.9 хувь буюу 491.9 мянган толгой, ямаа 23.0 хувь буюу 539.0 мянган толгойгоор тус тус буурсан байна.

Нийт мал сүргийн дотор тэмээ 0.6 хувь, адуу 6.2 хувь, үхэр 5.6 хувь, хонь 47.2 хувь, ямаа 40.3 хувийг тус тус эзэлж байна.

Малтай өрх 19813 байгаа ба үүний 88.1 хувь буюу 17464 нь малчин өрх байна. Эдгээр өрхийн тоо 2019 оныхоос малтай өрх 3.02 хувиар буюу 580 өрхөөр, малчин өрх 6.5 хувиар буюу 1066 өрхөөр тус тус нэмэгдсэн байна. Малчдын тоо 28333 болж өмнөх оноос 4.5 хувиар буюу 1232-оор өссөн байна. Нийт малчдын 30.5 хувь нь 15-34 насны, 57.8 хувь нь 35-59 насны, 11.7 хувь нь 60 болон түүнээс дээш насны малчид байна. Аймгийн малтай нэг өрхөд 226 толгой мал, нэг малчин өрхөд 256 толгой мал ноогдох байна. 1000 ба түүнээс дээш малтай 395 өрх байгаа нь өмнөх оныхоос 50.3 хувь буюу 399-өөр буурсан дүнтэй байна.

Нийт малтай өрхийн 2.2 хувь буюу 433 нь 10 хүртэл малтай, 7.4 хувь буюу 1464 өрх 11-30 хүртэл малтай, 7.8 хувь буюу 1549 өрх 31-50 хүртэл малтай, 16.1 хувь буюу 3193 өрх нь 51-100 хүртэл малтай, 26.1 хувь буюу 5166 өрх 101-200 малтай, 30.7 хувь буюу 6074 өрх 201-500 малтай, 7.8 хувь буюу 1539 өрх 501-999 малтай, 1.8 хувь буюу 348 өрх 1000-1499 малтай, 0.2 хувь буюу 37 өрх 1500-2000 малтай, 0.1 хувь буюу 10 өрх 2000-аас дээш малтай байна.

Оны эхэнд тоологдсон нийт малын 3.7 хувь буюу 210.4 мянган толгой мал зүй бусаар хорогдсон ба хорогдлын 89.2 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 0.6 хувь буюу 1.2 мянган толгой мал өвчнөөр хорогдсон байна.

Нийт 34622 толгой хээлтүүлэгчийн 59.8 хувийг хуц, ухна эзэлж байна. Нэг хээлтүүлэгчид 5 төрөл дээр 37 ингэ, 9 гүү, 33 үнээ, 86 эм хонь, 85 эм ямаа ногдох байна. Хээлтүүлэгч мал өмнөх оноос 13.8 хувиар буюу 5531 толгойгоор буурсан байна. Хэдийгээр мал аж ахуйн салбар нь аймгийн нийгэм эдийн засагт голлох үүргийг гүйцэтгэж байгаа боловч тус салбарт өнөөдөр хэтийг харсан бодлоготой

Үйл ажиллагаа дутагдаж, үйлдвэрлэл нь байгалиас хараат шинжтэй, эрсдэл даах чадавхи сул, нэгж малаас ашиглах ашиг шим бага, эрчимжилтийн түвшин доогуур, сүргийн зохистой бүтэц бүрдээгүй, бод малын хээлтуүлэгч дутагдалтай байгаа, бэлчээрийн даац багтаамж хэтэрсэн, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан малчдын ашиг орлого, амьжиргааны түвшин тогтвортой дээшилж чадахгүй байна.

### **1.2 Малын үржлийн ажлын талаар баримтлах бодлого боловсруулах үндэслэл:**

Аймгийн түвшинд Малын генетик нөөцийг зохистой түвшинд хадгалах, хамгаалах, сайжруулах, бэлчээр, тэжээлийн нөөц хангамж, байгаль цаг уур, нийгмийн соёлтой уялдуулан мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой өсгөх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд мал зүйн шинжлэх ухаан, түүний ололтыг нэвтрүүлэх үйл ажиллагааг далайцтай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуйн салбарыг онцгой анхаарч Улсын Их Хурал 2009 онд “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, 2010 онд “Монгол мал” үндэсний хөтөлберийг батлан хэрэгжүүлж, малын чанарыг сайжруулахаас гадна мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд төрөөс татаас олгож эхэлсэн нь малчид, мал бүхий иргэдийн амьжиргааг дэмжсэн үйл явц болсон.

Мөн Улсын Их Хурлаас 2016 онд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, 2017 онд “Малын генетик нөөцийн тухай” хууль, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай”, хууль, 2018 онд “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, 2020 онд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэргийг шинээр боловсруулан баталсан нь “Мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх” нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д “Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, үүлдэрлэг байдлыг сайжруулах бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ” гэж заасан бол Малын генетик нөөцийн тухай хуульд “Монгол улсад үржжүүлж байгаа мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүн болон тэдгээрийн нөөцийг бүртгэх, удам зүйн хувьд үнэлэх, төлөв байдлыг тодорхойлох түүнийг ашиглах, хамгаалах, судлан хөгжүүлэх, үндэсний генийн сан бий болгох, малын генетик нөөцтэй холбогдох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх” гэж заасан нь малчид, мал бүхий иргэдийг дэмжсэн, экспортыг нэмэгдүүлэх, малчин өрхийн амьжиргааг сайжруулах эрх зүйн таатай орчныг бий болгосон юм.

Мал аж ахуйн салбарын нөхөн үйлдвэрлэлийг төлөвлөн хэрэгжүүлж, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож нэмүү өртөг шингэсэн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бус нутгаар хөгжүүлж, бэлчээрийн мал аж ахуйн салбараас дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх зэрэг зайлшгүй анхаарах асуудлууд байсаар байна.

Мал аж ахуйн салбарт сүүлийн 3 жил дараалан зундаа гантай, өвөлдөө хүйтэн, отор нүүдэл ихтэй байсан нь мал аж ахуйн үйлдвэрлэлд бэрхшээл учруулж, төллөвөл зохих хээлтэгчийн 50 хувийг үржилд оруулаагүй, том малын зүй бус

хорогдол нэмэгдэж, олон арван малчин өрх огт малгүй болоогүй ч амьжираандаа хүрэхгүй цөөн малтай болсон байна.

Эдгээр хөтөлбөр, зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлэх, учирч болох ган зудын бэрхшээлийг хохирол багатай даван туулахад аймгийн мал аж ахуйн салбарт баримтлах бодлого чиглэл, стратегийн зорилтуудыг тодорхойлох явдал зайлшгүй шаардлагатай болж байгаа юм. Мөн таван төрлийн малд жил бүр хийгддэг хавар, намрын үзлэг ангилалтын дүн, 2018 онд хийсэн сумдын мал сүргийн түвшин тогтоо ажлын тайлан, 2019 онд хийгдсэн нийт мал сүргийн 1 хувьд төлөв байдлын үнэлгээ хийсэн ажлын тайлан зэрэгт үндэслэн энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулсан болно.

### **1.3. Уржлийн ажлын талаар баримтлах бодлогын алсын хараа, эрхэм зорилго, зорилт, хамрах хүрээ, хугацаа, санхүүжилт:**

**1.3.1. Алсын хараа:** Дэлхийн мал амьтны үнэт генетик нөөцэд хамаарагдах Монгол орны баталгаажсан үүлдэр, омгийн малыг цэвэрээр болон сайжруулагчаар ашиглан үржүүлж, үнэт чанарыг бататган хамгаалах, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржлийн ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй аймаг, орон нутагтаа зохион байгуулж, ашиг шимиийн гарц, чанарыг сайжруулан, зах зээлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх.

**1.3.2 Эрхэм зорилго:** Орон нутгийн байгаль экологийн онцлог, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар болгох. Эрхэм зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллана.

#### **1.3.3 Зорилтууд:**

1. Адуун сүргийн үржлийн ажил
2. Үхэр сүрэг, сарлагийн үржлийн ажил
3. Тэмээн сүргийн үржлийн ажил
4. Хонин сүргийн үржлийн ажил
5. Ямаан сүргийн үржлийн ажил

#### **1.3.4 Малын үржлийн талаар баримтлах бодлогын хамрах хүрээ, хугацаа, санхүүжилт**

##### **• Хамрах хүрээ**

Энэхүү дунд хугацааны бодлого нь аймгийн бүх сум, багт хэрэгжинэ. Хэрэгжүүлэгчид нь аймаг, сум, багийн бүх шатны удирдлага, мал аж ахуйн мэргэжилтэн, малчин, мал бүхий иргэд, фермерүүд байна.

##### **• Хугацаа**

Энэ нь дунд хугацааны буюу 6 жил (2022-2027)-д хэрэгжих бодлогын баримт бичиг юм.

##### **• Санхүүжилт**

**Бодлогын баримт бичгийн санхүүжилт нь жил бүрийн аймгийн нийт төсвийн 1 хувиас багагүй байна.**

##### **1. Адуун сүргийн үржлийн ажил**

##### **Хэрэгжүүлэх чиглэл:**

Монгол, Галшар үүлдэр, Дархад омгийн адууг өнөөгийн байдлаар уналга эдэлгээ, хурдны чиглэлээр үндсэн сайжруулагчаар түлхүү ашиглаж байна.

Цаашид эдгээр адуун сүргийн дотроос биерхүү, махан ашиг шим сайтай адууг сонгон үржүүлж мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сүү ихтэй гүүг сонгон үржүүлж саам, айраг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр заасан сум, багт хэрэгжүүлнэ. Дээрх адууг цэврээр нь дараах ашиг шимээр түлхүү үржүүлэх чиглэлийг баримтлана. Үүнд:

**1. Адууг уналга, эдэлгээ-махны чиглэлээр үржүүлэх:** Бүх бүс нутагт адууг уналга, эдэлгээ-махны чиглэлээр түлхүү үржүүлнэ. Махлаг шинж илүү хөгжсөн адууг сонгон авч өөр дотор нь үржүүлэн мах, махан бүтээгдэхүүний зах зээл дэх өрсөлдөх чадварыг дээшлүүлэх

**2. Адууг уналга, эдэлгээ-мах-сүүний чиглэлээр үржүүлэх:** Дархад омгийн ГҮҮ сүүлэг чанараараа бусад үүлдэр, омгийн гүүнээс илүү байдаг онцлогыг харгалзан цагаан гүүний саамыг эмчилгээ сувилалд ашиглах, төрөл бүрийн бүтээгдэхүүн хийж сурталчилах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдад түлхүү үржүүлэх;

**3. Адууг хурдны болон спортын чиглэлээр үржүүлэх;** Адууг хурдлах чадвараар сонгон, уламжлалт уралдаан, аялал жуулчлал, спортын шинэ төрлүүдэд тохирсон хэв шинжээр нь үржүүлэхийн зэрэгцээ хурдны болон аялал жуулчлал, спортын чиглэлээр сайжруулахад Монгол улсын Үүлдэр ашиг шимиийн зөвлөлөөс зөвшөөрсөн үүлдрийн адууг импортлон мэргэжлийн байгууллагын хяналтын дор үржлийн ажлыг явуулах.

### Адуун сүргийг үүлдэр, ашиг шимиийн чиглэлээр үржүүлэх бүс нутаг

№	Үүлдэр, омгийн нэр	Аймгийн хэмжээнд		
		Цөм сүргийн байршил	Тархалт	Үржүүлэх чиглэл
1	Монгол үүлдэр	Цөм сүрэг бүрдүүлнэ	Аймгийн бүх сум, багт тархсан	Уналга-эдэлгээ махны чиглэлээр бүх суманд үржүүлнэ
3	Галшар үүлдэр	Сайжруулагч аар ашиглана	Хархорин, Хужирт, Бүрд, Өлзийт, Есэнзүйл, Сант, Баян-Өндөр Хайрхандулаан, Баянгол, Төгрөг г.м	Хурдны болон спортын чиглэлээр нутгийн монгол адууны сайжруулагчаар ашиглана
4	Дархад омог	Сайжруулагч аар ашиглана	Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан	Уналга-эдэлгээ мах сүүний чиглэлээр тархалт бүхий сумдад цэврээр болон сайжруулагчаар ашиглана

### 2. Үхэр сүрэг, сарлагийн үржлийн ажил

#### Хэрэгжүүлэх чиглэл:

Үхэр сүргийн генетик нөөцийн ашиглалтыг сайжруулж, үүлдэрлэг байдал, ашиг шимиийн гарц, чанарыг дээшлүүлэхдээ дараах чиглэлээр өсгэн үржүүлнэ.

### **1. Махны чиглэлийн үхэр үржүүлэх:**

- Махны чиглэлийн үхэрт Монгол үүлдэр, Сэлэнгэ үүлдэр, Дорнод монголын улаан үүлдэр, сарлаг, хайнаг зэрэг нутгийн үхэр болон Герефорд, Казахын цагаан толгойт, хар, улаан Ангус зэрэг махны, төрөлжсөн үүлдруүд, тэдгээрийн эрлийзийг багтаах;

- Арвайхээр, Хархорин, Хужирт, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга, Бүрд, Өлзийт, Баян-Өндөр суманд эхний 3 жилд жил бүр 20 толгой, нийт 600 толгой шилмэл бухыг нийлүүлж дараагийн 3 жилд дээрх сумдаас бэлтгэсэн өсвөр бухаар бусад сумдыг хангах;

- Үхрийн мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, гадаад дотоодын зах зээлийн махны эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхийн тулд үхэр сүрэгт үржүүлэг селекцийн аргуудыг (цэвэр үржүүлэг, цус шингээх, хэрэгцээний эрлийзжүүлэг) ашиглан махан ашиг шимиин чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх;

- Үхэр сүрэгт явуулах үржлийн ажилд мөрдлөг болгон ажиллах, төлөвлөгөөнд заасны дагуу үхэр сүргээ тасралтгүй өсгөх үүргийг сум орон нутагт хариуцуулах;

- Шилмэл хээлтүүлэгч болон сүрэг сэлбэх үржлийн гунжийг цөм сүргийн аж ахуй, донор аж ахуйгаас бэлтгэн сайжруулагчаар ашиглахад мэргэжлийн байгууллага үйлчилгээ үзүүлэх;

- Махны чиглэлийн нутгийн болон төрөлжсөн үүлдрийн үхэр, сарлагт жил бурийн 10-р сард багтаан мэргэжлийн ангилагч-шинжээч ангилалт хийж анги чанарыг тогтоох, сүрэг сэлбэх, чанарын шаардлага хангасан үр болон хөврөлийг технологийн дагуу бэлтгэн зохиомол хээлтүүлэг хийх, хөврөл шилжүүлэн суулгах.

### **2. Сарлагийн үхэр үржүүлэх:**

- Сарлагт явуулах селекцийг сумын түвшинд, малчдын аравтын бүлэг, сайн дурын холбоо, хоршоо зэрэг малчдын хамтын байгууллагад төвлөрүүлэх;
- Уянга сумын “Шуранга, Ар царам”-ын сарлагийн цөм сүргийг сонгон үржүүлж генетик нөөцийг зүй зохистой ашиглах замаар сарлагийн чанар, үүлдэрлэг байдлыг дээшлүүлэх;
- Уянга сумын “Шуранга, Ар царам”-ын сарлагийн ашиг шим, гальбирын судалгааны арга зүйг боловсруулан батлуулж арга зүйн дагуу судалгааны ажлыг хийж үр дүнг гаргах ;
- Сарлагийн тоог сүргийн зохистой бүтцийг чанд баримтлан өсгөх, махлаг шинжээр шилж үржүүлэх;
- Сарлаг үхэрт зохиомол хээлтүүлэг хийж, үр дүнг тооцох;

### **3. Сүүний болон хосолмол ашиг шимт үхэр үржүүлэх:**

- Сүүний болон хосолмол ашиг шимт Хар тарлан, Симменталь, Алатау , Буган халиун зэрэг сүүний чиглэлийн үхрийг аймгийн төв болон томоохон сумын төвийн ойролцоо саалийн аж ахуй эрхлэх бүс нутгийг шинэчлэн тогтоох;
- МУСҮТөвөөс үржүүлгийн бүтээгдэхүүнийг эрчимжсэн аж ахуй эрхлэх бүс нутгийн аж ахуй эрхлэгч фермерүүдэд нийлүүлэх, зохиомол хээлтүүлэгт хамруулах;
- 2023 онд жилд дунджаар 2500-аас доошгүй л сүү саадаг 50 толгой, 2026 онд жилдээ дунджаар 2750 л-ээс доошгүй сүү саадаг 250 толгой үнээг тус тус сүүний чиглэлийн үхрийг үржүүлэх тогтоогдсон бүсэд үржүүлэх;

- 2023 онд 25 үнээтэй 2, 2026 онд 50 үнээтэй 5 саалийн аж ахуйтай болох;
- Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн гарвал ашиг шимиийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах, 2023 онд сүүний чиглэлийн нийт үнээний 100 хувь бүртгэлд бүрэн хамруулах.

Сүүний болон хосломол ашиг шимт эрлийз үнээнд цус шингээх эрлийзжүүлгийн аргыг хэрэглэн 3-р үеэс өөр дотор нь үргүүлэх замаар ашиг шимиийн түвшинг нэмэгдүүлнэ. Харин нутагшсан цэвэр үүлдрийн сүүний болон хосломол ашиг шимт үнээнд импортын гаралтай шилмэл бух болон удамшлын чанар өндөртэй бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийнэ.

#### Үхрийн ашиг шим, үржлийн чанарыг сайжруулах бүс нутаг:

№	Үүлдэр, омгийн нэр	Аймгийн хэмжээнд		
		Цөм сүргийн байршил	Тархалт	Үржүүлэх чиглэл
1	Монгол үхэр	Бүх сумдад цөм сүрэг бүрдүүлнэ	Бүх суманд	Мах-сүүний чиглэлээр үржүүлнэ.
2	Сарлаг үхэр	Уянга, Бат-Өлзий, Хархорин	Сарлаг бүхий сумдад үржүүлнэ	Мах-сүүний чиглэлээр удам дагуулан үржүүлнэ. Уянга суманд Шуранга, Арцармын сарлагийн удам бий болгож үржүүлнэ.
3	Дорнод монголын улаан	Сайжруулагчаар ашиглана.	Хангайн сумдаас бусад сумдад	Мах-сүүний чиглэлээр
4	Сэлэнгэ	Сайжруулагчаар ашиглах	Хархорин, Хужирт, Зүүнбаян- Улаан, Бүрд, Өлзийт, Есөнзүйл, Баян-Өндөр, Тараагт, Арвайхээр, Хайрхандулаан	Цэврээр үржүүлэхийн хамт, нутгийн монгол үхрийн махан ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр үржүүлнэ
5	Герефорд, Казахын цагаан толгойт, хар, улаан Ангус		Арвайхээр, Хархорин	Цэврээр үржүүлэх
6	Хар тарлан	-	Арвайхээр, Хархорин	Хот суурин газар, зах зээл, дэд бүтцийг түшиглэн эрчимжсэн технологиор цэврээр үржүүлэх
7	Алатау, Буга н халиун	-	Есөн-Зүйл, Арвайхээр, Хархорин, Хужирт	
8	Симменталь	-	Арвайхээр, Хархорин	

#### 3. Тэмээн сүргийн үржлийн ажил

### Хэрэгжүүлэх чиглэл:

• Тэмээн сүргийг түүний үржлийн чанараар үржлийн цөм сүрэг, үржлийн үндсэн сүрэг, хэрэгцээний сүрэг хэмээн ангилж, үржлийн цөм сүргээс удам үндэслэгч буур, ингийг шалгаруулан өөр дотор нь нийлүүлж, гарсан удмын буураар үржлийн үндсэн сүргийн ээлжийн ингийг хээлтүүлж сайжирсан төл гарган авна. Цөм сүргийн буурыг ашиглан нутгийн тэмээг сайжруулах ажлыг цус шингээх эрлийзжүүлгийн аргаар явуулна.

### Тэмээний ашиг шим, үржлийн чанарыг сайжруулах бүсийн чиглэл:

№	Үүлдэр, омгийн нэр	Аймгийн хэмжээнд		
		Цөм сүргийн байршил	Тархалт	Үржүүлэх чиглэл
1	Монгол	Тэмээ бүхий сумд	Тэмээ бүхий сумд	Ноос-мах-уналга-эдэлгээ
2	Галбын говийн улаан	Сайжруулагчаар ашиглах	Богд, Баянгол, Төгрөг, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Сант	Ноос-мах-уналга-эдэлгээ
3	Ханын хэцийн хүрэн үүлдэр	Сайжруулагчаар ашиглах	Богд, Баянгол, Төгрөг, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Сант	Ноос-мах-уналга-эдэлгээ
4	Ламын гэгээний улаан үржлийн хэсэг	Сайжруулагчаар ашиглах	Богд, Төгрөг,	Богд, Төгрөг, суманд сүү-ноос
5	Монголын хоолойн тэмээ	Гучин-Ус сум	Богд, Гучин-Ус, Баруунбаян-Улаан сум	Өөр дотор нь цэврээр нь Max-ноос-уналга – эдэлгээний чиглэлээр үржүүлнэ.

### 4. Хонин сүргийн үржлийн ажил:

#### Хэрэгжүүлэх чиглэл:

Хонин сүргийн генетик нөөцийн ашиглалтыг сайжруулж, үүлдэрлэг чанар, ашиг шимиийн гарц, амьдрах чадварыг дээшлүүлэхдээ нутгийн монгол хонийг "Баянгол" омог, Барга, Баяд үүлдрээр сайжруулах, махны чиглэлээр Керей, Суффолк, Дорпер, Эдельвай зэрэг үүлдруудийг хэрэгцээний эрлийзжүүлэгт (нэгдүгээр үеийн эрлийзийг төл бурийг маханд ашиглах) ашиглах чиглэлээр өсгөн үржүүлнэ. Нийт мал сүрэгт 47.0-оос дээш хувьд нь хонин сүрэг байхаар төлөвлөн хонины үржлийн ажлыг хэрэгжүүлнэ.

#### 1. Max-өөх-бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт хонь үржүүлэх:

- Max, ноосон ашиг шимийг сайжруулах чиглэлээр цэврээр сонгон үржүүлэхийн зэрэгцээ бүдүүвтэр ноост унаган омог Баянгол, Барга, Баяд үүлдрээр сайжруулж, амьдын жин, ноосны гарц, чанарыг нэмэгдүүлэх, мах-өөхний чиглэлийн төрөлжсөн үүлдрийн хониор нутгийн монгол хонинд хэрэгцээний

эрлийзжүүлгийг эрчимтэй хэрэгжүүлэх аргаар өсвөр хонины мах үйлдвэрлэлийг дагнан тууштай явуулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх;

- Баталгаажсан үүлдрийн хонины цөм сүргээс сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгчийг гэрээ, захиалгын дагуу чиглэлтэй өсгөн бойжуулж, мэргэжлийн байгууллагын хяналтын дор зах зээлд нийлүүлэх замаар жишигт тэнцсэн хээлтүүлэгчийг үржилд ашиглаж, стратеги зорилтуудыг хэрэгжүүлэх;

- Үржлийн ажил, үйлчилгээний оновчтой тогтолцоог сум, орон нутгийн түвшинд бий болгож, бог малын хээлтүүлэгчийг тэдний өмч, эзэмшилд шилжүүлэн үржил селекцийн ажлыг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах нөхцлийг бүрдүүлэх;

#### **Хонин сүргийг ашиг шимиийн чиглэлээр үржүүлэх бүс нутаг**

Үүлдэр, омгийн нэр	Аймгийн хэмжээнд			Үржүүлэх чиглэл
	Цөм сүргийн байршил	Тархалт		
<b>A. Мах-өөх-бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт хонь</b>				
1	Монгол	Цөм сүрэг бүрдүүлнэ	Бүх сумдад тархсан	Баянгол омгийн хонины үржлийн цөм сүрэг бүхий сумдаас бусад сумдуудад үржүүлнэ
2	Баянгол омог	Цөм сүрэг бүрдүүлнэ	Сант, Баян-Өндөр, Төгрөг, Гучин-Ус, Хужирт, Бүрд, Хархорин	Говийн болон тал хээрийн сумдад сайжруулагчаар ашиглана.
3	Барга үүлдэр	Сайжруулагчаар ашиглах	Бүх сумдад тархсан	Баянгол сумын Баянгол омгийн цөм сүргээс бусад тал хээрийн сумдуудад сайжруулагчаар ашиглах
4	Баяд үүлдэр	Сайжруулагчаа р ашиглах	Хангайн сумдууд	Хангайн сумдад сайжруулагчаар ашиглах
<b>B. Мах-өөх-бүдүүн ноосны чиглэлийн ууцан сүүлт хонь</b>				
1	Суффолк, Эдельвай, Дорфер, Керей үүлдэр	Хэрэгцээний үржүүлэгт ашиглана	Бүх суманд	Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр хэрэгцээний болон цус шингээх аргыг хэрэглэх. Өрхийн төвшинд хэрэгцээний эрлийзжүүлэг явуулах.

#### **5. Ямаан сүргийн үржлийн ажил:**

##### **Хэрэгжүүлэх чиглэл:**

Ямаан сүргийн генетик нөөцийн ашиглалтыг сайжруулж, үүлдэрлэг чанар, ашиг шимиийн гарц, чанарыг дээшлүүлэхдээ кашимер ноолуурын чиглэлээр Тээлийн хүрэн нутгийн шилмэл хэвшлийн ямааг удам дагуулан үржүүлж, Эрчим хар, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямааг сайжруулагчаар ашиглан нутгийн монгол ямааны амьдрах чадвар, амьдын жин, ноолуурын чанарыг сайжруулна. Нийт мал сүрэгт эзлэх ямааны хувийн жинг 34.5 хувь болгож бууруулах бодлого баримтална.

**Кашимер ноолуурын чиглэлийн ямаа үржүүлэх:** Манай аймаг зөвхөн кашимер ноолуурын чиглэлийн ямааг үржүүлнэ. Нутгийн монгол ямааны амьдрах

чадвар, ашиг шимиийг сайжруулах зорилгоор Эрчим хар, Баяндэлгэр улаан үүлдрийн ямааг ашиглана.

- Эрчим хар үүлдрийн ямааг, хангайн сумдын ямааны үндсэн сайжруулагчаар ашиглах;
- Баяндэлгэр улаан үүлдийн ямааг тал хээр,.govийн сумдын ямааны үндсэн сайжруулагчаар ашиглах;
- Нутгийн монгол ямааг стандартад нийцүүлэн үржлийн цөм сүрэг бий болгож, өөр дотор нь цэврээр нь үржүүлэхийн хамт, сайжруулагч үүлдрүүдийг ашиглан амьдрах чадвар, ашиг шим, ноолуурын чанарыг сайжруулах;
- Ямааны үржлийн ажлын гол зорилго нь амьдрах чадвар, амьдын жин, ноолуурын чанар (мкм)-ыг сайжруулахад чиглэгдэнэ.

**Ямааны аж ахуйг хөгжүүлэх бүс нутаг:**

№	Үүлдэр, омгийн нэр	Аймгийн хэмжээнд		
		Цөм сүргийн байршил	Тархалт	Үржүүлэх чиглэл
1	Монгол	Цөм бүрдүүлнэ сүрэг	бүх суманд	Нутгийн монгол стандартад нийцүүлэн үржлийн цөм сүрэг бий болгож, өөр дотор нь цэврээр нь үржүүлнэ
2	Эрчим хар	Сайжруулагчаар ашиглах	Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан, Уянга	Ноолуур, махны чиглэлээр нутгийн монгол ямааны үндсэн сайжруулагчаар ашиглах
3	Баяндэлг эрийн улаан	Сайжруулагчаар ашиглах	Тал хээр,.govийн сумдад	Тал хээр.govийн сумдад үндсэн сайжруулагчаар ашиглана
4	"Тээлийн хүрэн" НШХ	Нарийнтээл сум	Нарийнтээл сумын 1,3 дугаар багт	өөр дотор нь цэврээр нь үржүүлнэ

Аймгийн үржлийн ажлын бодлогыг хэрэгжүүлэхдээ малчдын сүргийн эргэлтийг жил бүр тооцож, малд үзлэг, ангилалт хийж, ашиг шимиийн түвшинг тогтоож, ялан тэмдэглэж бүртгэлжүүлэн, үржлийн ажлыг бүртгэлтэй явуулж, хэрэгцээний эрлийзжүүлгийг түлхүү хийнэ. Ингэснээр малчдын орлого нэмэгдэж, малын тооноос чанарт шилжсэн үр дүн хүлээгдэж байна. Үүний тулд хөрөнгө санхүүг нэмэгдүүлэх, дутагдалтай байгаа мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх шаардлага байгаа.